

**ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН 2025 ОНЫ
ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ
ХИЙСЭН АЖЛЫН ТОВЧ ТАЙЛАН**

2026.01.18

Нэг. Зорилго, арга зүй

Иргэний нисэхийн ерөнхий газар /ИНЕГ/-ын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өгөх, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал, зөвлөмж боловсруулах замаар яамны удирдлага, албан тушаалтныг холбогдох мэдээллээр хангах зорилгоор энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг гүйцэтгэлээ.

Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг дүгнэхдээ Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Хяналт-шинжилгээ хийх журам”, “Үнэлгээ хийх журам”, “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”, мөн оны 183 дугаар тогтоолоор баталсан “Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн биелэлтэд хяналт тавих нийтлэг журам”, 2022 оны 352 дугаар тогтоолоор баталсан “Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам”, Зам, тээврийн сайдын 2025 оны А/310 дугаар тушаалаар баталсан “Зам, тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлж дүгнэх журам”-ыг тус тус үндэслэл болгосон.

Хоёр. Танилцуулга

ИНЕГ-ын үйл ажиллагааг 2025 оны жилийн эцсийн байдлаар Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилт, Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, Сайдын тушаалын хэрэгжилт, Нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээ, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт гэсэн 7 үзүүлэлтээр дүгнэсэн бөгөөд нэгдсэн дүнгээр 77.4%-тай үнэлэгдлээ.

Эдгээрийг тус тусад нь авч үзвэл:

2.1. МУ-ын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт:

Арга хэмжээний тоо	Хэрэгжилтийн явц зорилтот түвшин				Хэрэгжилтийн хувь
	85 хувь буюу түүнээс дээш “үр дүнтэй”	60-84 хувь буюу “үр дүн хүлээгдэж байгаа”	30-59 хувь буюу “үр дүн хангалтгүй”	0-29 хувь буюу “үр дүн гараагүй”	
7	5	-	2	-	80%

2.2. МУ-ын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилт:

Арга хэмжээний тоо	Хэрэгжилтийн явц зорилтот түвшин				Хэрэгжилтийн хувь
	85 хувь буюу түүнээс дээш “үр дүнтэй”	60-84 хувь буюу “үр дүн хүлээгдэж байгаа”	30-59 хувь буюу “үр дүн хангалтгүй”	0-29 хувь буюу “үр дүн гараагүй”	

2.3. ИНЕГ-ын 2025 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт:

Нийт	Үүнээс				Хэрэгжилтийн хувь
	100%	Хэрэгжих шатанд	0%	Хугацаа болоогүй	
147	81	66	-	-	81,4%

2.4. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт:

Нийт заалт	Үүнээс					Хэрэгжилтийн хувь
	Хэрэгжсэн	Хэрэгжих шатанд	Хэрэгжээгүй	Хугацаа болоогүй	Хэрэгжих боломжгүй	
7	6	1	-	-	-	92.9%

2.5. Сайдын тушаалаар өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт:

Нийт заалт	Үүнээс					Хэрэгжилтийн хувь
	Хэрэгжсэн	Хэрэгжих шатанд	Хэрэгжээгүй	Хугацаа болоогүй	Хүчингүй болсон	
87	48	4	3	19	13	90,9%

2.6. Нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээ:

д/д	Үзүүлэлтийн бүлэг	Үнэлгээ (хувь)
1	Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал	88,1%
2	Хүний нөөцийн талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал	64,3%
3	Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал	70,2%
4	Үзүүлж байгаа үйлчилгээний талаарх ил тод, нээлттэй байдал	61,8%
5	Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал	67,2%
Дүн		74,5%

2.7. Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ:

Мэдээлэл оруулах тоо	Мэдээлэл оруулсан тоо	Үүнээс:			Гүйцэтгэлийн хувь
		Хугацаандаа	Хоцорсон	Мэдээлээгүй	
178	178	167	11	-	93.8%

Гурав. Үнэлэлт, дүгнэлт
Төлөвлөлтийн байдал:

ИНЕГ нь 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулахдаа ХШҮДАГ-аас өгсөн зөвлөмжийн дагуу арга хэмжээнүүдийг хариуцах хэлтэс, албадыг нэр заан тусгаж, хэрэгжүүлэх арга хэмжээний хүрэх түвшнийг улирлаар хуваан яамны төлөвлөгөөтэй уялдуулан төлөвлөсөн боловч тухайн арга хэмжээг хэрэгжүүлэхэд яам болон ИНЕГ, ИНҮТ-ийн оролцох үүрэг, хариуцлагыг ялгаатай тодорхойлох зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Мөн Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор “Хяналт-шинжилгээ хийх журам”, “Үнэлгээ хийх журам”, “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам” шинэчлэн батлагдсантай холбоотой байгууллагуудын Гүйцэтгэлийн төлөвлөгөөний суурь болон зорилтот түвшинг тоо, хувиар илэрхийлж болохуйцаар шалгуур үзүүлэлтийг тодорхойлж, өөрчлөлт оруулах шаардлагатай байна.

Хэрэгжилтийн байдал:

1) ИНЕГ-ын 2025 оны үйл ажиллагааг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилт, Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, Сайдын тушаалын хэрэгжилт, Нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээ, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт гэсэн 7 үзүүлэлтээр дүгнэсэн бөгөөд нэгдсэн дүнгээр 77.4%-тай үнэлэгдсэн байна.

2) Яам, тээврийн яамнаас 2025 оны 10-11 сард яам болон харьяа байгууллагуудын “Хяналт шалгалт болон аудитын тайлангаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт-д дотоод аудит хийж, ИНЕГ-ын хэрэгжилт 21,6 хувь буюу хангалтгүй үнэлэгдсэн байна.

Хяналт шалгалт, аудит, хяналт-шинжилгээ хийсэн байгууллага	Акт, албан шаардлага, зөвлөмжийн тоо			Хувь
	Нийт	Үүнээс		
		Хэрэгжсэн	Хугацаа болоогүй	
ҮАГ	28	7	-	25%
ЗГХХГ	11	1	2	11,1%
Нийт	39	8	2	21,6%

Энэ нь зөвлөмж, албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлээгүйгээс гадна хэрэгжилтийг хангах төлөвлөгөөг боловсруулахдаа хэрэгжүүлэх арга хэмжээг оновчтой тодорхойлоогүй, хугацааг бодитой тооцоолоогүй, хариуцах эзэн нь тодорхой бус төлөвлөсөн, хэрэгжилтийг баримтад суурилан тайлагнаагүй, нотлох баримтыг хавсарган ирүүлээгүй зэргээс шалтгаалсан байна.

3) Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан хэрэгжилт хангалтгүй байгаа 34 арга хэмжээний 22 нь бодлого, стратеги, төлөвлөгөө, дүрэм, журам, аргачлал, стандарт боловсруулах, судалгаа хийх, зөвлөмж, заавар өгөх, үзлэг шалгалт хийх зэрэг хөрөнгө санхүүжилт шаардагдахгүй, удирдлага, зохион байгуулалтыг сайжруулан хийх боломжтой ажлууд байна.

4) Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг зорилтуудаар нь авч үзвэл:

Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжилтийн хувь
Зорилт 1: Олон улсын нислэг үйлдэх эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлнэ.	12	75.8%
Зорилт 2: Эрх зүйн баримт бичгийг боловсронгуй болгоно.	11	82.7%
Зорилт 3: Олон улсын иргэний нисэхийн байгууллага (icao)-ын стандарт, шаардлагад нийцүүлэн монгол улсын агаарын навигацийн үйлчилгээний аюулгүй, үр ашигтай, хүртээмжтэй байдлыг бодлого, зохицуулалтаар хангана.	5	71.4%
Зорилт 4: Агаарын тээврийн салбарын хүрээлэн буй орчинд үзүүлж буй сөрөг нөлөөллийг багасгах арга хэмжээ авах, нисэхийн аюулгүй байдал, аюулгүйн хамгаалалтын хяналт, зохицуулалтыг хэрэгжүүлэх, бодлого, зохицуулалтаар хангана	5	86%
Зорилт 5: Олон улсын туршлага, чиг хандлагатай уялдуулан нисэх буудлын үйл ажиллагааны бодлогын санал боловсруулах, бодлогын хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх	17	69.4%
Зорилт 6: Иргэний нисэхийн салбарын аюулгүй байдлын зохицуулалтыг хийнэ.	30	90%
Зорилт 7: Иргэний нисэхийн салбарт зохицуулалтыг үнэмлэхжүүлэлт, гэрчилгээжүүлэлтээр хийх.	11	100%
Зорилт 8: Иргэний нисэхийн үйл ажиллагаанд мэргэжлийн хяналт тавина.	5	100%
Зорилт 9: Осол зөрчил давтагдахаас урьдчилан сэргийлнэ.	1	50%
Зорилт 10: Иргэний нисэхийн хяналт, зохицуулалтын мэдээллийн ил тод байдлыг хангана.	2	85%
Зорилт 11: Олон улсын иргэний нисэхийн байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлнэ.	8	65%
Зорилт 12: Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллаар хангана.	12	73.3%
Зорилт 13: Салбарын хууль тогтоомж, дүрэм журмыг шинэчлэхэд болон хэрэгжүүлэхэд мэргэжил, арга зүйн зөвлөгөө, удирдлагаар хангана.	15	80.7%
Зорилт 14: Үр ашиггүй зардлыг бууруулж, батлагдсан төсвөө хэмнэнэ.	6	93.3%
Зорилт 15: Бодлого, хөтөлбөр, төсөл, хууль тогтоомж, засгийн газрын тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангуулахад дэмжлэг үзүүлнэ.	2	100%
Зорилт 16: ИНЕГ-ын үйл ажиллагаанд дотоод аудит хийх, эрсдэлийн удирдлагаар хангана.	2	90%
Зорилт 17: иргэний нисэхийн аюулгүй байдлыг сайжруулна.	3	73.3%
Зорилт 18: иргэний нисэхийн аюулгүй байдлыг хангуулах, өгөгдлийн сангийн бүртгэл хөтлөх, хяналт тавих.	2	70%
Нийт		81,4%

5) 2025 онд 2.3 сая зорчигч, 12.0 мянган тн ачаа тээвэрлэхээр төлөвлөснөөс 2,448,414 зорчигч 12,3 мянган тонн ачаа тээвэрлэсэн үзүүлэлттэй,

Монгол Улсын 2025 оны Төсвийн тухай хуулиар батлагдсан хуваарийн дагуу улсын төсөвт 80.0 тэрбум төгрөгийг бүрэн төвлөрүүлсэн байна.

6) 2024 он болон 2025 оны эхний хагас жилийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж өгсөн зөвлөмжүүдээс дараах зөвлөмжүүдийн хэрэгжилт хангалтгүй хэвээр байна. Үүнд:

- ИНЕГ-ын албан хаагчдыг төрийн албан хаагч болгох, албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн батлуулах зэрэг ажлуудыг 2025 оны I сард багтаан дуусгах,
- Монгол Улс, АНУ хооронд шууд нислэг үйлдэх бэлтгэл ажлыг эрчимжүүлж, 2025 онд багтаан нислэгийг эхлүүлэх;
- 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг яаралтай батлан I улиралд багтаан сонгон шалгаруулалтуудыг зохион байгуулах, ИНЕГ-ын хөрөнгө оруулалтаар болон урсгал зардлаар хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах;
- Иргэний нисэхийн ерөнхий газрын дунд хугацааны стратеги төлөвлөгөө, Иргэний нисэхийн аюулгүй ажиллагааны журам, Иргэний нисэхийн аюулгүй ажиллагааны үндэсний төлөвлөгөө, Албадлагын дүрэм, Ажилтнуудын нийгмийн баталгааг хангах хөтөлбөр зэрэг бичиг баримтуудыг батлах хөрөнгө, санхүүжилт шаардагдахгүй ажлуудыг яаралтай дуусгах;

Дөрөв. Санал, зөвлөмж

1. ИНЕГ-т ажиллаж буй албан хаагчдыг төрийн албаны ерөнхий шалгалтад хамруулах, албан тушаалын тодорхойлолтуудыг шинэчлэн Төрийн албаны зөвлөлөөр хянуулан батлуулах, төрийн албаны ерөнхий шалгалтад тэнцсэн, шаардлага хангасан албан хаагчдыг яаралтай томилох, үлдсэн сул ажлын байранд “Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам”-д заасны дагуу тусгай шалгалтыг зохион байгуулж, шаардлага хангасан иргэдийг томилох зэрэг ажлуудыг 2026 оны I улиралд багтаан дуусгах;
2. Байгууллагын эрсдлийг тодорхойлж, эрсдлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө батлан хэрэгжүүлж ажиллах;
3. Эрх бүхий байгууллагаас хийсэн хяналт шалгалт, аудит, хяналт-шинжилгээний хүрээнд өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд тавих дотоод хяналтыг сайжруулан хэрэгжүүлэх төлөвлөгөө гаргаж, хэрэгжилтийг холбогдох байгууллагуудад тогтоосон хугацаанд нотлох баримт материалын хамт бүрэн тайлагнаж хэвших;
4. 2026 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг яаралтай батлан I улиралд багтаан сонгон шалгаруулалтуудыг зохион байгуулах, ИНЕГ-ын хөрөнгө оруулалтаар болон урсгал зардлаар хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах;
5. Нислэгийн тоо, чиглэлийг нэмэгдүүлэх болон Монгол Улс, АНУ хооронд шууд нислэг үйлдэх бэлтгэл ажлыг эрчимжүүлэх;

6. Иргэний нисэхийн аюулгүй байдлын журам, үндэсний төлөвлөгөө батлах, Иргэний нисэхийн ерөнхий газрын дунд хугацааны стратеги төлөвлөгөө, салбарын хүний нөөцийн стратеги, Ажилтнуудын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрүүдийг шинэчлэх зэрэг санхүүжилт шаардахгүй хэрэгжүүлэх боломжтой ажлуудыг яаралтай дуусгах зохион байгуулалтын арга хэмжээ авах;
7. Олон улсын туршлага, чиг хандлагатай уялдуулан нисэх буудлын үйл ажиллагааны бодлогын санал боловсруулах, бодлогын хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх зорилтын хүрээнд төлөвлөсөн ажлууд, ялангуяа нисэх буудлуудын бүтээн байгуулалтын ажлыг зохион байгуулалтаар ханган ИНҮТ ТӨХХК-тай чиг үүргээ нарийвчлан тогтоож, хамтран ажиллах;
8. 2026 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулахдаа дараах зүйлсийн анхаарах. Үүнд:
 - Тухайн арга хэмжээг хэрэгжүүлэхэд ИНБЗГ болон ИНЕГ, ИНҮТ болон бусад харьяа байгууллага, компаниудын оролцох үүрэг, хариуцлагыг ялгаатай тодорхойлж, хэрэгжүүлэх хугацааг уялдуулах.
 - Суурь болон зорилтот түвшинг тоо, хувиар илэрхийлж болохуйцаар шалгуур үзүүлэлтийг тодорхойлж, улирал бүрээр хүрэх боломжтой, бодитойгоор төлөвлөх.

**ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ НЭГДСЭН ДҮН**

№	Хяналтад байх арга хэмжээ	2025 онд төлөвлөсөн нийт арга хэмжээ	Тухайн улиралд төлөвлөсөн арга хэмжээ	Хэрэгжилтийн хувь	Жинлэсэн хувь
1	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	7	7	80	20
2	Монгол Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт	6	6	41.7	20
3	Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт	147	147	81.4	20
4	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт	7	7	92.9	20
5	Сайдын тушаалын хэрэгжилт	87	55	90.9	10
6	Нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээ	50	50	74.8	10
7	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	178	178	93.8	10
Нийт				77.4	